



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/64

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Сумын 2024 оны төсөв батлах тухай" 06 дугаар тогтоол, сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/42 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Шивээговь сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хүрээнд сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 3-н төрөлт тэмцээн зохион байгуулсугай.


2.Тэмцээний удирдамжийг 1 дүгээр, зарцуулагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Спортын тэмцээнд зарцуулагдах 458,000 (дөрвөн зуун тавин найман мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан арга хэмжээний зардлаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  СУГАРМАА

2024 оны 05-р сарын 15-ны өдрийн
1164 дугаар захирамжийн 1-р хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ
“БИД ХАМТДАА” НӨХӨРСӨГ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

ЗОРИЛГО: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулах, хөгжүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ:

- ✓ Шагай
- ✓ Даам
- ✓ Багийн хөгжөөнт буухиа

ТЭМЦЭЭНД ТАВИГДАХ ШААРДАЛГА:

- ❖ Нэг баг 8-10 гишүүнтэй байна.
- ❖ Даамны төрөлд эрэгтэй-2, эмэгтэй-2 тамирчин оролцоно.
- ❖ Шагай хамах тэмцээнд эрэгтэй-4, эмэгтэй-4 тамирчин оролцоно.
- ❖ Багийн хөгжөөнт буухиад эрэгтэй-3, эмэгтэй-3 тамирчин оролцоно.
- ❖ Тэмцээнд оролцох баг тамирчид 2024.05.18-ны 09:00 цагт мэдүүллэгээ өгнө.


ЗОХИОН БАЙГУУЛАХ ӨДӨР: 2024

ХАМРАХ ХҮРЭЭ:

- Шивээговь сум

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ: Багуудыг тэмцээн тус бүрийн нийлбэр оноогоор байр эзлүүлж нэг, хоёр, гуравдугаар байр тус бүрийг Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаана.

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗДТГ**



Сумын Засаг даргын
2024 оны 05 -р сарын 15 -ны өдрийн
#164 дугаар захирамжийн 2-р хавсралт

Говьсүмбэр аймгийн шивээговь сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд
зохион байгуулах “Би чадна” хөгжөөнт тэмцээний төсөв

2024 оны 05 сарын 13 өдөр

Д/д	Бараа материал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Зардал, задаргаа	
				Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл фото цаас	ш	1	18000	18000
2	Өргөмжлөлийн жааз А4	ш	3	15,000	45.000
3	Тэргүүн байрын шагнал	төгрөг	1	100000	100000
4	Дэд байрын шагнал	төгрөг	1	80000	80000
5	Гутгаар байрны шагнал	төгрөг	1	60000	60000
6	Шуудай	ш	3	1000	3000
7	Шаар	ш	40	200	8000
8	Ундаа	ш	24	2000	48000
9	Ууттай печень	ш	48	2000	96000
10	Нийт дүн				458000

ТӨСӨВ ГАРАГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН

МЭРГЭЖИЛТЭН: *AC*

Б.АЛТАНСҮХ